



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/193

Хажуу шинэ-Ус

Цагийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/490 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдаа үйлчилгээний эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг өвлийн цагийн хуваарьт шилжүүлсүгэй.

2.Худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүрүүдийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл өглөө 09:00 цагаас оройн 19:30 цаг хүртэл ажиллахаар тогтоосугай.

3.Найман нэрийн дэлгүүрүүд сар бүрийн нэгэнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), Хэсгийн цагдаа (Б.Наранбаатар), Өрнөлт багийн Засаг дарга (Л.Батбаатар) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/55 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Т.АРИУНАА

482401093